



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 26 өдөр

Дугаар А/203

Хэрлэн сум

Хүүхдийн баярын өдрийг тэмдэглэн  
өнгөрүүлж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 7 дугаар зүйлийн 7.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2, 58.2.17, 65 дугаар зүйлийн 65.1.1, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан журмын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхдийн баярын өдрийг 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, арга хэмжээний удирдамжийг 2 дугаар, зарцуулагдах хөрөнгийн төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүүхдийн баярын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах 2500000 /хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц сангийн болзошгүй зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /Ж.Ганбаатар/-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Хүүхдийн баярын өдрийг харьяа нутаг дэвсгэртээ тэмдэглэн өнгөрүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Тус өдрийн үйл ажиллагааг удирдамжийн дагуу зохион байгуулж, арга хэмжээний тайланг сумдаас авч нэгтгэн Нийгмийн бодлогын хэлтэст 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /Б.Энх-Эрдэнэ/-д даалгасугай.


5. Арга хэмжээний гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2017 оны 05...  
дугаар сарын 26 өдрийн 1/203 дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



Хүүхдийн баярын өдрийг  
тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсэг

Ажлын хэсгийн дарга:

-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого  
төлөвлөлтийн хэлтсийн дарга

-Боловсрол, соёл урлагийн газрын дарга

-Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын  
Захирагч

-Биеийн тамир спортын газрын дарга

-Эрүүл мэндийн газрын дарга

-Мэргэжлийн хяналтын газрын дарга

-Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн  
дарга

-Цагдаагийн газрын Хэв журмын тасгийн дарга

-Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний  
газрын дарга

-Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын дарга

-Нийтийн номын сангийн захирал

-Музейн захирал

-Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын

Бор-Өндөр-2 орон нутгийн хөгжлийн хөтөлбөр

Нарийн бичгийн  
дарга

-Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын  
дарга



## ХҮҮХДИЙН БАЯРЫН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

### I. АГУУЛГА

Монгол улс жил бүрийн 6 дугаар сарын 01-нийг Хүүхдийн баярын өдөр болгон 1952 оноос тэмдэглэж эхэлсэн бөгөөд дэлхийн ихэнх улс орнуудад хүүхдийн баярыг энэ өдөр тэмдэглэдэг. Манай орон хүүхдийн баярыг үндэсний хэмжээнд, амралтын өдөр болгон хуульчлан тэмдэглэдэг цөөн орны нэг юм. 1995 оноос Эх үрсийн баяр болгосон ба иргэдийн санал хүсэлтийн дагуу 2003 оноос дахин Хүүхдийн баяр болгон тэмдэглэсээр өнөөг хүрсэн юм. Энэ жилийн хувьд "Хүүхэд гэр бүлдээ жаргалтай" олон нийтийн санаачилгын хүрээнд зохион байгуулагдана.

### II. ЗОРИЛГО

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг нийтэд сурталчлах, хүүхдийн хөгжил, хамгаалал, тогтвортой гэр бүл, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлага, хүүхдэд ээлтэй гэр бүлийн орчин, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, хүүхэд, гэр бүлд зориулсан үйлчилгээг дэмжих, нэвтрүүлэх, нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгаалалд төр төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн тэгш оролцоог хангах зорилготой.

### III. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

АЗДТГ, Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хэрлэн сумын ЗДТГ, ЭМГ, БСГ, Биеийн тамир спортын газар, МХГ, БОАЖГ, ХХҮХ, Хан Хэнтий чуулга, Ясли, Замын цагдаагийн тасаг, ЕБС-үүд, цэцэрлэгүүд, Ясли, Номын сан, Аймгийн Музей, "Өндөрхаан" нисэх буудал, Аймгийн Скаутын холбоо, ДЗМОУБ-ын Бор-Өндөр-2 хөтөлбөр, Хаан банкны Хэнтий салбар, Төрийн банкны Хэнтий салбарууд тус тус хамтран зохион байгуулна.

### IV. ХАМРАХ ХҮРЭЭ

Чингис хотын хүүхэд, гэр бүлүүд

### V. ХУГАЦАА

5 дугаар сарын 30-наас 6 дугаар сарын 1-ний хооронд

### VI. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- Төв талбай дээр нээлтийн арга хэмжээг шинэлэг байдлаар зохион байгуулах /хүүхдүүдийн жагсаал /парад/, флашмоб, роликтой хүүхдүүдийн мэндчилгээ, 100 бүжигчин хүүхдийн мэндчилгээ/
- Төв талбай дээр баярын өдрөөр хүүхдэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагаа, уралдаан тэмцээн зохион байгуулна
- Хэвлэл мэдээллийн бүх эх үүсвэрийг ашиглан шинээр гарсан хууль тогтоомжийг сурталчилсан постер, видео шторк бэлтгэж цацна.




- Хүүхдийн баярын өдрийг тохиолдуулан зохион байгуулж буй гар зургийн үзэсгэлэн, хүүхдийн тайлан тоглолт, жүжиг, үзүүлбэр зэрэг арга хэмжээг дэмжиж ажиллана.
- Үйл ажиллагааны удирдамж, чиглэл гаргаж сумд, байгууллагуудад тараан тайланг авч нэгтгэнэ.
- Хамтран ажиллах байгууллагуудыг нэгдсэн аргазүйгээр хангаж, өртөө хариуцуулж ажиллуулна.
- Хүүхдийн оролцооны байгууллагууд аймаг орон нутгийн удирдлагуудтай уулзаж санал бодлоо солилцож, дуу хоолойгоо хүргэнэ
- Хүнд нөхцөлд байгаа хүүхдүүдэд тусламж үйлчилгээ хүргэнэ
- Байгууллагуудыг ажилтнуудын гэр бүлээ дэмжих, хүүхэддээ цаг гаргах, хүүхдийн эрхийн чиглэлээр тогтмол сургалт, нөлөөллийн ажил хийж хэвшихэд уриалах
- Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон үзвэр үйлчилгээ, уралдаан тэмцээнийг өргөнөөр зохион байгуулах, үүнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцоог хангах, ингэхдээ хүүхдийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд харгалзах
- Зохион байгуулж байгаа арга хэмжээнүүдэд аль болох гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангахыг эрмэлзэх
- "Хүүхэд гэр бүлдээ жаргалтай" олон нийтийн санаачилгыг сурталчилж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

## **VII. БУСАД**

- Баярын арга хэмжээ явагдах төвлөрсөн газрууд, үйлчилгээний цэгүүдэд хогийн сав байршуулах, хүүхэд эцэг эхчүүдэд хандан хогийн саванд хогоо хаях талаарх зөвлөмж, сануулгыг тохиромжтой хэлбэрээр байрлуулах
- Хүүхдийн баярын өдрөөр ресторан, кафе зэрэг нийтийн хоолны үйлчилгээний газрыг эрүүл хүнсний бүтээгдэхүүн, хүүхдийн менюгээр үйлчлэх санал тавьж,
- Баярын арга хэмжээ болох газруудад барааны төвлөрсөн худалдаа явуулахыг хориглох
- Хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд хортой бараа бүтээгдэхүүн зарахыг хориглож мэргэжлийн байгууллагуудаар хяналт тавиулах
- Хүүхдийн баярын өдрөөр архи, тамхи худалдаалахгүй байх бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх

**Холбоо барих утас:** 98143533 98184418 70563533

Аймгийн Засаг даргын 2017 оны 05  
 дугаар сарын 26 өдрийн 1/03 дугаар  
 захирамжийн гуравдугаар хавсралт



ХҮҮХДИЙН БАЯРЫН ӨДРӨӨР  
 ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр		Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хариуцах
1	Баннер	Тайз чимэглэл /үлгэрийн ордон босгох/			354,000	354,000	
		Өртөөнүүдийн хаяг	M2	1,2*10	8,000	160,000	
2	Хүүхдийн бэлэг	Тоглолтод оролцох хүүхдүүд	ш	141	8000	1128,000	
		Хүүхдээ сонсьё уулзалтад оролцогч хүүхдүүдийн бэлэг	ш	15	10000	150,000	
3	Нисэх загварын тэмцээний шагнал	1-р байр	ш	4	30,000	120,000	
		2-р байр	ш	4	20,000	80,000	
		3-р байр	ш	4	10,000	40,000	
		Тусгай байр	ш	4	5,000	20,000	
		1-р байр /баг/	ш	1	100,000	100,000	
	Цардмал замын зургийн уралдаан	1-р байр	ш	2	10,000	20,000	
		2-р байр	ш	2	8,000	16,000	
		3-р байр	ш	2	6,000	12,000	
		Тусгай байр	ш	2	5,000	10,000	
4	Шохой /цардмал замын уралдаанд ашиглах		Хайрцаг	30	3,000	90,000	
5	Аппартур хөгжим /түрээслэх/		удаа	1	200,000	200,000	
	Дүн					2,500,000	